

**БНМАУ-ЫН ТӨРИЙН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ,
ТҮҮНИЙГ ЗӨВШӨӨРӨН ХҮЛЭЭСЭН НЬ**

Л.Хашбат, хууль зүйн ухааны дэд эрдэмтэн

Октябрийн социалист их хувьсгалын нөлөөгөөр, МАХН-ын удирдлагаар 1921 онд Монгол оронд ардын хувьсгал ялсан билээ. Ардын хувьсгалт шинэ Монгол Улс 1921 оны 7 дугаар сарын 11-нд байгуулагдав. “Феодалын хамжлагат мөлжлөг, нийгмийн болон үндэсний элдэв дарлалыг бүрмөсөн устгаж, социалист шинэ нийгэм байгуулан, хөдөлмөрчин ард түмэнд жинхэнэ эрх чөлөө, аз жаргалыг олгож, нийгэм-эдийн засгийн олон зуун жилийн хоцрогдлыг арилгаж, эх орноо хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн социалист улс болгон хувиргасан нь”¹⁸ БНМАУ-ын 60 гаруй жилийн хөгжлийн гол үр дүн юм.

БНМАУ анх үүсч байгуулагдсан цагаасаа эхлэн олон улсын хууль зүйн субъектын хувьд улс орнуудад өнөөгийн олон улсын хууль зүйн тавьж байгаа бүхий л шаардлагад нийцсэн бүрэн эрхт улс байлаа.

Монголын Ардын Засгийн газар 1921 оны 9 дүгээр сарын 14-нд бусад орны засгийн газарт хандаж гаргасан мэдэгдэлдээ, тусгаар тогтносон Монгол Ард Улс байгуулсан тухай зарлан мэдэгдэж, тэгш эрх, сайн хөршийн зарчмын үндсэн дээр дэлхийн олон оронтой дипломат болон ажил хэргийн харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм. Түүний хамт Монголын Ардын Засгийн газар Монголын ард түмний өөртөө засан тохинох эрхээ хэрэгжүүлж байгааг иш үндэс болгон Монгол Улсад тулган хүлээлгэсэн эрх тэгш биш бүх гэрээ, түүний дотор Хятадын эрх мэдлийн дор автономит улс байгуулах тухай 1915 оны Хиагтын хэлэлцээрийг өөртөө засан тохинох зарчимд харш учир хүчингүй болгосныг мэдэгдсэн билээ.

Хөрөнгөтөн улсын засгийн газрууд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөс эрс татгалзан хойш сууж, тус улсыг Хятадын нутаг дэвсгэрийн нэг хэсэг гэж үзэн, Хятадын засгийн газрын зүгээс Монгол оронд хууль бусаар өнгөлзөж байсныг илэрхий дэмжиж байлаа. Тухайлбал Хятадтай харилцах асуудлаар 1922 оны 2 дугаар сарын 6-нд Вашингтонд АНУ, Япон, Хятад, Англи, Франц, Итали, Бельги, Нидерланд, Португали улсын төлөөлөгчид гарын үсэг зурсан “есөн гүрний гэрээ”² гэгчид Монгол Улсын хүлээн зөвшөөрөхгүй байх гэ-

¹ Ардын хувьсгалын 50 жилийн ойд бэлтгэх тухай МАХН-ын Төв Хорооны тогтоол, “Үнэн” 1970 оны 7 дугаар сарын 20

² “Вашингтонская конференция по ограничению вооружений и тихоокеанскому и дальневосточному вопросам 1921-1922 годов” М., 1924, стр 78.

сэн империалист бодлого тусгалаа олсон байдаг. Энэ нь нэг талаас тусгаар тогтносон, ардын эрхт Монгол Улс бий болж Зөвлөлт Орос улстай нягт хэлхээ холбоо тогтоосон явдал хөрөнгөтөн орны эрх баригчдын таалалд нийцээгүй, нөгөө талаас тэд тэр үед Хятадыг хамжин мөлжих зорилгоор “нээлттэй хаалгын” бодлого явуулж, түүнийг Монголд хамтатган хэрэгжүүлэхийг эрмэлзэж байсныг гэрчилж байна.

Империалистууд манай улсыг багалзуурдан дарж, БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа түүний дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох хэрэглүүр болгон ашиглахыг санаархаж байв. Тухайлан Хаалган хотод сууж байсан Америкийн консул Сокобин Монголд ирж, Ардын Засгийн газрыг ганцаардуулах зорилт тавих, Монгол-Хятадын хооронд АНУ-аар зуучлуулахыг ноёд лам нарт хүсч, эдийн засгийн тусламж амлаж байв.³ Японы империализм Монгол Улсыг булаан эзлэх төлөвлөгөө зохиож, 1930-аад онд БНМАУ-д зэвсэгт халдлага хийж байлаа. Түүнийг өрнөдийн гүрнүүд дипломатын болон бусад шугамаар дэмжиж байв.

Гагцхүү Зөвлөлт улс л Монгол Ард Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудлаар тууштай, зарчимч байр суурь баримталж байв. Зөвлөлт Засгийн газар хаант оросоос Монголын талаар байгуулсан бүх гэрээ хэлэлцээрийг цуцалж, Монголын ард түмэн өөртөө засан тохиох үндсэн дээр тусгаар тогтнож бие даан аж төрөх эрхийг хүлээн зөвшөөрсөн билээ. ЗСБНХОУ-ын Гадаад хэрэг эрхэлсэн Ардын комиссарын газар Монголын Засгийн газарт ирүүлсэн ноот бичигтээ “Оросын хөдөлмөрчин олон түмэн, тэдний хүсэл зоригийг илэрхийлж байгаа ажилчин, тариачин засгийн газар нь Монголын Ардын хувьсгалт засгийн газар байгуулагдаж, найрамдалт Монголын ард түмэн харийн талхинаас чөлөөлөгдсөнд чин сэтгэлийн баяр хүргэж байна”⁴ гэж тэмдэглэжээ. Зөвлөлт Засгийн газар Монгол Улсыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоохоос өмнө ч гэсэн Монголын ард түмний тусгаар тогтнол, бүрэн эрхийг тууштай хамгаалж байлаа. Монголын ардын Түр Засгийн газрын хүсэлтээр манай оронд цэргийн тусламж үзүүлж, дараа нь шинэ тулгар Монгол Улсын аюулгүй байдал, олон улсын байдлыг бэхжүүлэхээр дэмжлэг үзүүлсэн юм.

Монгол Улс, ЗСБНХОУ-ын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай хэлэлцээрт 1921 оны 11 дүгээр сарын 5-нд Москва хотноо гарын үсэг зурсан билээ. Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нь тэр хэлэлцээрийн улс төрийн үндсэн агуулга болж байв. Хэлэлцээрийн дагуу ЗСБНХОУ-ын Засгийн газар “Монголын Ардын Засгийн газрыг Монгол Улсын хууль ёсны цорын ганц засгийн газар хэмээн хүлээн зөвшөөрч” Монголын Ардын Засгийн газар “Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улсын засгийн газрыг Оросын хууль ёсны цорын ганц засгийн газар хэмээн хүлээн зөвшөөрсөн хэрэг байлаа. Тус хоёр орны засгийн газар улмаар дипломат харилцаа тогтоож, дипломат болон консулын төлөөлөгчид солилцохоор хэлэлцэн тохирсон юм. Хаант Оросын Засгийн газар, автономит Монголын Засгийн газрын хооронд байгуулсан хуучны бүх гэрээ хэлэлцээр нь хоёр оронд цоо шинэ байдал бий болсны улмаас хүчингүй болсныг хэлэлцээрт албан ёсоор нотолсон байна. Хоёр этгээд улс

³ “Документы внешней политики СССР”, т.IV стр. 370

⁴ “Документы внешней политики СССР”, т.IV стр. 216

төр, эдийн засгийн харилцаандаа бие биедээ нэн тааламжтай нөхцөлийн зарчмыг хэрэгжүүлэх боллоо. Тэгш эрхэд тулгуурласан энэ хэлэлцээр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны цаашдын хөгжлийн хууль зүйн суурийг тавьж өгсөн юм.

Хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа Д.Сүхбаатар зэрэг Монголын бүрэн эрхт төлөөлөгчийг Зөвлөлт Засгийн газрын тэргүүн В.И.Ленин хүлээн авч ярилцахдаа, Монгол Улсын гадаад байдлыг дүгнэн үзээд “Танай орны хөдөлмөрчин бүрийн зөв зам бол Зөвлөлт Орос улсын ажилчин, тариачидтай холбоо тогтоож улс төр, аж ахуйнхаа тусгаар тогтнолын төлөө тэмцэх явдал мөн”⁵ гэж тэмдэглэсэн билээ. В.И.Лениний энэ зөвлөгөө МАХН, Ардын Засгийн газрын гадаад бодлогын үндэс нь болж өгсөн юм.

Зөвлөлт Орос улс тэр үед Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, хэвийн харилцаа тогтоосон анхны их гүрэн, цорын ганц улс байв. ЗХУ ийнхүү Монгол Улсыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоож, Зөвлөлт Холбоот Улсаас манай улсад үзүүлсэн улс төр, эдийн засгийн болон цэргийн тусламж дэмжлэг нь БНМАУ-ын тусгаар тогтносон бүрэн эрхт улсын хувьд оршин тогтнохын шийдвэрлэх хүчин зүйл болсон юм. Ингэснээр БНМАУ-ыг дипломат шугамаар ганцаардуулах гэсэн империалист бодлого нуран унасан билээ.

1924 оны 11 дүгээр сарын 26-нд Улсын анхдугаар их хурал тус улсын анхны Үндсэн хуулийг баталж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхагласан явдал манай орны тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхийг хуульчлан бататгаж, ардын ардчилсан Монгол улс олон улсын харилцааны эрх тэгш субъект мөнийг дэлхий дахинаа нотлон харуулав. Энэ нь БНМАУ-ын олон улсын хууль зүйн байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

1930-аад онд БНМАУ-д зэвсэгт халдлагын аюул занал тулгарч байсантай холбогдуулан 1934 оны 11 дүгээр сарын 27-нд БНМАУ, ЗХУ-ын хооронд аль нэг нь цэрэг дайны халдлагад өртвөл бие биедээ харилцан дэмжлэг үзүүлэх тухай аман хэлэлцээр байгуулсан юм. Уг хэлэлцээрийг 1936 онд 3 дугаар сарын 12-нд харилцан туслах тухай 10 жилийн хугацаатай протокол болгосон билээ. Ингэснээр БНМАУ-ын талаарх Японы милитаристууд, тэрчлэн Монголын тусгаар тогтнолыг устгахыг санаархаж байсан Хятадын цэргийн эрхтнүүд, гоминданы эрх баригч бүлгийнхний түрэмгий төлөвлөгөөг биелэх боломжгүй болгосон юм. Японы милитаристууд 1939 онд БНМАУ-д халдан довтлоход холбоотны үүрэгтээ үнэнч ЗХУ Монголын ард түмэнд дав даруй цэргийн тусламж үзүүлж, түрэмгийллийг няцаасан билээ. Үүний зэрэгцээ ЗХУ манай орны бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг империалист өнгөлзлөгөөс дипломат шугамаар хамгаалах арга хэмжээ авч байлаа. Тухайлбал, 1941 оны 4 дүгээр сард Москвад Зөвлөлт-Японы хэлэлцээ хийх үеэр Зөвлөлт Засгийн газрын шургуу шаардлагаар “Япон Улс БНМАУ-ын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн бөгөөд халдашгүй дархан байдлыг хүндэтгэх үүрэг” авчээ.⁶ Үүнээс үзэхэд Японы Засгийн газар зөвхөн БНМАУ-ын оршин тогтнож байгааг зөвшөөрөн хүлээгээд зогсоогүй, түүний нутаг дэвсгэрийн халдашгүй эрхийг хүндэтгэх болсон байна.

Монголын тусгаар тогтнолын асуудлаарх Хятад улсын байр суурь БНМАУ-ыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх явдалд

⁵ В.И.Ленин, Т. 44, стр 232.

⁶ “Правда” 1941, IV. 14.

гол саад тотгор болж байв. 1921 онд Монгол оронд хувьсгал ялж, тусгаар тогтносон ардын төр үүсч байгуулагдсан бодит байдлыг Хятадын милитаристууд дараа нь гоминданы эрх баригч бүлгийнхэн хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй байлаа. Тэд Монгол Улсын бүрэн эрхт байдалд өнгөлзсөөр байв.

Өнө удаан хугацааны турш зорин тэмцэж, тоо томшгүй зовлон зүдгүүрийг амсан байж эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олсон Монголын ард түмэн улс орондоо хятадын ноёрхол ямар нэгэн хэлбэрээр тогтохын эсрэг байсан нь зүйн хэрэг билээ.

Манай ард түмэн Зөвлөлт улсын дэмжлэгт тулгуурлан улсынхаа тусгаар тогтнолыг эрс шийдвэртэй хамгаалахдаа өөртөө засан тохинох салшгүй эрхээ үндэс болгож байсан юм. БНМАУ-ын тусгаар тогтнолыг дэмжиж байсан Хятадын ардчилсан хүчний зүгээс Монгол Ард Улсын ийм шударга байр суурийг бүрнээ ойлгож байлаа. ХКН-ын Төв Хорооны сонин “Манай ард иргэд Монголын асуудалд хэрхэн хандах ёстой вэ?” гэсэн өгүүлэлдээ, милитарист эзэрхэг түрэмгий этгээдүүд Монгол Улсыг байлдан эзлэх тухай хашгирч байхад хөдөлмөрчид бид Монголын бие даасан байдлыг дэмжиж, Монголын ард түмний эрх чөлөөг бэхжүүлэхийн төлөө тэмцэх ёстой”⁷ гэж бичиж байлаа.

Монголын Засгийн газар Хятадын харгис хүчний хорт явуулгатай тэмцэхдээ БНМАУ-ын бүрэн эрхийг хүндэтгэх үндсэн дээр Хятад улстай энх түвшин найрсаг харилцаа тогтоохын тулд өөрийн зүгээс ихээхэн хүчин чармайлт тавьж байсан юм. Тухайлан Монгол Улсын Засгийн газар тус орны тусгаар тогтнолыг зарлан тунхагласан тухай 1921 оны 9 дүгээр сарын 14-ний мэдэгдэлдээ монголчууд “урьдын адил Хятад улстай найрсаг харилцаатай байж, Монгол-Хятадын худалдааны харилцааг сэргээхийг хүсч байна. Монгол, Хятад хүмүүс бие даан амар түвшин аж төрж болох юм”⁸ гэж цохон тэмдэглэсэн билээ. БНМАУ түүнээс хойш тус орны тусгаар тогтнолыг Хятад улс хүлээн зөвшөөрөх үндсэн дээр хоёр орны харилцааг хэвийн болгоход ээлэн байгааг удаа дараа илэрхийлж байсан юм. Гэтэл энэ талаар БНМАУ-ын авч явуулсан бүхий л алхмыг Хятадын Засгийн газар няцааж, элдэв шалтаг заан, даруй 25 жилийн турш тус улсыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байв.

ЗХУ дэлхийн II дайнд шийдвэрлэх ялалт байгуулж, Германы фашизм, Японы милитаризмыг бут цохих нийтийн үйлст БНМАУ хувь нэмрээ оруулсан нь Хятадын гоминданы Засгийн газрын БНМАУ-д өнгөлзөх харгис бодлогоо орхиж, тус улстай хэвийн харилцаа тогтоох замд ороход хүргэсэн юм.

1945 оны 2 дугаар сард ЗХУ, АНУ, Английн тэргүүн нарын оролцсон Ялтын бага хурал дээр зөвлөлтийн хүчин чармайлтаар БНМАУ-ын төр-хууль зүйн бүрэн эрхийг нотолсон билээ. Энэ үндсэн дээр, мөн оны дундуур Москвад болсон Зөвлөлт-Хятадын хэлэлцээний явцад Хятадын засгийн газар БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөхөө мэдэгдсэн боловч тус орны төрийн тусгаар тогтнолын тухай асуудлаар нийтийн санал хураах болзол тавьж, 1945 оны 8 дугаар сарын 14-нд Зөвлөлт Засгийн газарт өгсөн нот бичигтээ тэр тухай албан ёсоор дурджээ. Тийм шаардлага тавьсан нь БНМАУ-ыг Хятад улс албан ёсоор хүлээн зөвшөөрөхийг

⁸ “Сяньдао Чжоубао” 1922. IX. 27, № 3.

⁹ “Революционные мероприятия Народного правительства Монголии в 1921-1924 гг. Документы” М., 1960., стр 137.

бас нэг удаа сунжруулах гэсэн түүний оролдлого байлаа. Гоминданы эрх баригч бүлгийнхэн ингэхдээ Хятад улс өөрөө л Монголд тусгаар тогтнол олгож, сайн дураараа тийм алхам хийж байгаа мэтээр харуулахыг оролдож байлаа.

Үүний хамт Хятадын Засгийн газрын дээр дурдсан мэдэгдэл нь БНМАУ-ыг Хятад улс хууль зүйн үүднээс албан ёсоор хүлээн зөвшөөрснийг нотлон тогтооход ач холбогдолтой болсон юм. БНМАУ үүнийг харгалзан үзэж, хятадын ард түмэнтэй найрамдал, сайн хөршийн харилцаа бэхжүүлэхийг эрмэлзэн нийтийн санал хураах тухай санааг зөвшөөрч, ингэх нь 1921 онд Монгол Ард Улс жинхэнэ тусгаар тогтнолоо байлдан олсныг нотлох нэг хэрэглүүр гэж үзсэн билээ. БНМАУ-д 1945 оны 10 дугаар сарын 20-нд нийт ард түмний санал хураалт явуулсан нь нэгэнт байгуулсан ардын төр улсаа хамгаалан бэхжүүлэх Монголын нийт ард түмний хүсэл зоригийг бүрнээ нотолсон билээ. Хятадын засгийн газар 1946 оны 1 дүгээр сарын 5-нд БНМАУ-ыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, 2 дугаар сарын 13-нд манай улстай дипломат харилцаа тогтоосон юм.

Монголын ард түмэн улс төр, нийгэм-эдийн засгийн байгуулалтдаа ихээхэн амжилт олж, БНМАУ-ын олон улсын нэр хүнд бэхжиж, ЗХУ манай орны амин чухал эрх ашгийг тууштай хамгаалж байснаас гоминданы Засгийн газар тус улсын тусгаар тогтнолыг ийнхүү арга буюу хүлээн зөвшөөрөхөд хүрчээ.

Хятадын ардын хувьсгалын ялалтын дүнд БНХАУ байгуулагдсанаар БНМАУ-ын гадаад болон олон улсын байдал бэхэжсэн билээ. БНМАУ, БНХАУ-ын засгийн газрыг 1949 оны 10 дугаар сарын 6-нд хүлээн зөвшөөрч, мөн сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон юм. 1850 онд ЗХУ, БНХАУ хоёр албан мэдэгдэлдээ “1945 онд явуулсан нийтийн санал хураалт хийгээд тус оронтой БНХАУ дипломат харилцаа тогтоосны дүнд БНМАУ-ын тусгаар тогтносон байдал бүрэн хангагдсаныг хоёр орны Засгийн газар тэмдэглэж байна”⁹ гэсэн нь БНМАУ-ын тусгаар тогтол, бүрэн эрхт байдал олон улсын хууль зүйн үүднээс бас нэг шинэ нотолгоогоор баяжсан юм. Тийнхүү нотолсон нь Монгол-Хятадын харилцааны үүднээс одоо ч чухал ач холбогдолтой хэвээр байна.

БНМАУ, БНХАУ-ын хооронд байгуулсан хэд хэдэн хэлэлцээр, тухайлан хоёр орны харилцааны олон улсын хууль зүйн үндсэн зарчмыг тодорхойлсон 1960 оны 5 дугаар сарын 31-нд байгуулсан найрамдал, харилцан туслах тухай гэрээ нь Монгол-Хятадын харилцааг хууль зүйн үүднээс бататгаж өгсөн юм. Энэхүү гэрээний дагуу хэлэлцэн тохирогч хоёр этгээд бие биеийн төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, аль нэгнийхээ дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх үүрэг авчээ. Хилийн гэрээнд 1962 оны 12 дугаар сарын 26-нд Бээжин хотноо гарын үсэг зурж, Монгол-Хятадын хилийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн билээ.

Дээр дурдсанаас үндэслэн, БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хятад улс эргэлт буцалтгүй бүрэн зөвшөөрөн хүлээсэн бөгөөд энэ нь олон улсын хууль зүйн зохих баримт бичгүүдэд тодорхой тусгагдсан юм гэсэн дүгнэлт хийж болно.

Ардын ардчиллын хэд хэдэн орон бий болж, дэлхийн социалист систем үүсэн тогтсоноор БНМАУ-ын олон улсын байр суурь мэдэгдэхүйц бэхжин, улс төр, эдийн засаг, соёлын харилцаа холбоо нь өргөжиж ирсэн билээ.

⁹ “Документы внешней политики СССР”, т.VII, стр 710.

БНМАУ 1950 он гэхэд социалист ихэнх оронтой, тухайлан БНАСАУ, БНАГУ, Польш, Болгар, Чехословак, Унгар, Румынтэй дипломат харилцаа тогтоон, дипломат төлөөлөгчдөө солилцсон байлаа. Улмаар БНАВУ, Югослав, Кубатай хэвийн харилцаа тогтоолоо. БНМАУ ба социалист бусад орны хооронд албан ёсны найрсаг харилцаа тийнхүү тогтон хөгжиж эхэлсэн нь манай улсын байр суурийг олон улсын тавцанд ихэд бэхжүүлэв.

Социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай дипломат харилцаа тогтоосон нь БНМАУ-ыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх явдалд шинэ үе шат нээсэн юм.

БНМАУ-ыг социалист хамтын нөхөрлөлийн орнууд тийнхүү дор бүрийдээ хүлээн зөвшөөрсний хууль зүйн болон улс төрийн гол үр дагавар гэвэл, юуны өмнө манай орнуудын хооронд албан ёсны харилцаа тогтон олон талт нягт хамтын ажиллагаа өрнөж, ах дүү социалист орнууд олон улсын тавцан дээр манай улсын бүрэн эрхт байдал, хууль ёсны эрхийг бүх талаар идэвхтэй хамгаалж ирсэн явдал билээ.

БНМАУ-ын тууштай энх тайванч гадаад бодлого, Ази тивд тус улсын эзэлж буй байршил, социалист орнуудтай, тэрчлэн Ази-Африкийн дэвшилт улс орнуудтай хамтран империализм, колончлолын эсрэг, олон улсын энх тайван, аюулгүй байдлын төлөө цөхрөлтгүй тэмцэж ирсэн зэрэг нь БНМАУ-ыг олон улсын хэмжээнд, тэр тусмаа Ази-Африкийн улс түмний дунд улам нэр хүндтэй болгож, БНМАУ ба дэлхийн энэ хэсгийн улс орнуудын хооронд дипломат харилцаа тогтоох нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа БНМАУ социалист бусад орны нэгэн адил Ази, Африкт тусгаар тогтносон шинэ тулгар улс орон үүсэн тогтож олон улсын тавцан дээр гарч ирсэн явдалд баяр хүргэж, дэлхийн бусад улс түмэнтэй энх тайвнаар зэрэгцэн орших үндсэн дээр найрамдан нөхөрлөх гэсэн эрмэлзлийг нь талархан дэмжиж ирлээ. Үүний нэг тод илрэл нь манай улс Ази, Африкийн орнуудын Бандунгийн анхдугаар бага хурлын шийдвэрийг бүрэн дүүрэн дэмжсэн явдал бөгөөд энэ нь Ази, Африкийн улс түмний харилцан ойлголцох явдлыг бэхжүүлэх, улмаар БНМАУ, Ази Африкийн тусгаар тогтносон улсууд хоорондоо ойртож, албан ёсны найрсаг харилцаа тогтоосон улсууд хоорондоо ойртож, албан ёсны найрсаг харилцаа тогтооход чухал ач холбогдолтой зүйл болсон юм. Үүнтэй уялдуулан хэлэхэд Ази-Африкийн улсуудын хоорондын харилцааны үндэс бол энх тайван зэрэгцэн орших зарчим мөн гэж тунхагласан Бандунгийн бага хурлыг санаачлан хуралдуулахад гол үүрэг гүйцэтгэсэн Энэтхэг, Бирм, Индонез Улс нь Ази-Африкийн бусад орноос хамгийн түрүүнд БНМАУ-тай дипломат харилцаа явдал санамсаргүй хэрэг бишээ. БНМАУ мөн дээрх зарчмын үндсэн дээр үндэсний шинэ тулгар улсуудтай албан ёсны найрсаг харилцаа тогтоосон юм. БНМАУ социалист орны хувьд шинээр үүсэн тогтож байгаа бүрэн эрхт улс орон, ардчилсан засгийн газар бүхэнд хамгийн түрүүнд баяр хүргэж, хууль зүйн үүднээс ямар ч яриа хөөрөөгүй албан ёсоор бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч ирэв. Үүнд БНМАУ Ази, Африк, Латин Америкийн 50 шахам шинэ улс орныг хүлээн зөвшөөрчээ. Социалист орнууд түүний дотор БНМАУ эдгээр орныг ингэж нэн даруй албан ёсоор хүлээн зөвшөөрч, эрс шийдвэртэй дэмжиж байгаа нь тусгаар тогтнолыг нь бэхжүүлэн, олон улсын амьдралд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлж байгаа хэрэг юм.

БНМАУ тусгаар тогтносон улс орнуудтай хэвийн харилцаа тогтоосон явдал эдгээр оронтой найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд чухал алхам болсон юм.

Хөрөнгөтөн орнууд БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзан хойш сууж байсныг дээр дурдсан билээ. Ялтын хэлэлцээрийг¹⁰ судалж үзэхэд 1945 онд АНУ, Англи хоёр БНМАУ-ыг тусгаар тогтносон улс гэж хүлээн зөвшөөрөөд зогсоогүй, тийнхүү хүлээн зөвшөөрөхийг Хятадын гоминданы засгийн газарт зөвлөн ятгаж байжээ. Гэтэл АНУ, хөрөнгөтөн бусад орон “хүйтэн дайны” ерөнхий байр суурьт захирагдан БНМАУ-ын талаар хүлээсэн олон улсын үүргээ хөсөрдүүлж, манай улсыг албан ёсоор “үл зөвшөөрөх”, хавчин гадуурхах бодлого баримталж байв. Өрнөдийн гүрнүүд БНМАУ-ыг “хүлээн зөвшөөрөхгүй” гэдгээр шалтаглан, НҮБ болон олон улсын бусад байгууллагад тус улсын хууль ёсны эрхийг эдлүүлэхэд 15 жилийн турш зориуд саад тотгор хийж байв. БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхэд ийнхүү саад хийж байсан нь олон улсын энэ байгууллагад социалист орнуудын байр суурийг бэхжүүлэхгүй байх гэсэн империалист гүрнүүдийн санаархлын нэг илрэл байлаа.

БНМАУ-ын энх тайванч гадаад бодлого, тус улсын хууль ёсны эрх, олон улсын тавцан дээр эрх ашгийг нь хамгаалахад чиглэсэн ЗХУ, социалист бусад орны идэвхтэй тэмцэл, түүнчлэн энхийг эрхэмлэгч бусад улс орон, дэлхийн өргөн олон нийтийн дэмжлэг нь АНУ, түүний холбоотныг арга буюу ухрахад хүргэж, манай улс 1961 онд НҮБ-д байраа эзэлсэн юм. БНМАУ олон улсын байгууллага, олон этгээдийн гэрээ хэлэлцээрт оролцож байгаа нь нийгмийн өөр өөр байгуулалтай улс орны хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тийм байгууллага, гэрээний хүрээнд тус дөхөм үзүүлж, улмаар олон улсын хамтын нийгэмлэгийн дотор БНМАУ-ын байр суурийг улам бэхжүүлж байна. Нөгөөтэйгүүр, аль нэгэн улс орныг зарим нэг орон хүлээн зөвшөөрөхгүй байх нь тухайн тэр улсыг олон улсын нээлттэй байгууллага, олон этгээдийн гэрээнд оролцоход саад тотгор болж чадахгүй бөгөөд болох ч ёсгүй гэдгийг олон улсын олон талт хамтын ажиллагаанд БНМАУ-ын оролцож ирсэн практик ажиллагаа бат нотолж байна.

Хөрөнгөтөн орнууд БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөхөөс хойш сууж байсан хэдий боловч эдийн засгийн болон бусад бодит шалтгааны эрхээр төрөл бүрийн харилцаа холбоо тогтоохоос аргагүй болж, БНМАУ-ыг үнэн хэрэг дээрээ янз бүрийн хэлбэрээр зөвшөөрөн хүлээдэг болсон юм. Үүнийг гэрчлэх олон баримтын зөвхөн зарим нэгийг дурдахад: манай улстай хөрөнгөтөн орнууд дипломат харилцаа тогтоох хүртлээ худалдаа-эдийн засаг, соёлын талаар албан ёсны бус болон хагас албан ёсны харилцаа холбоо тогтоож, янз бүрийн төлөөлөгч, бие хүмүүс, нот бичиг, илгээлт солилцож, БНМАУ хөрөнгөтөн орнууд хамтран олон улсын байгууллага, бага хурал, олон этгээдийн гэрээ хэлэлцээрт оролцож ирсэн билээ. Иймэрхүү харилцаа холбоо тогтон хөгжиж ирсэн нь манай улсын империалистуудын “үл зөвшөөрөх” бодлого, БНМАУ бол “бие даасан улс биш”, “олон улсын хууль зүйн бүрэн эрхт субъект биш” гэж номлодог байсан харгис онолын аль аль нь удаан наслах үндэс суурьгүй болсныг харуулсан юм. Нөгөөтэйгүүр энэ нь хэд хэдэн хүчин зүйлээс юуны өмнө

¹⁰ “Алс Дорнодын асуудлын талаар гурван их гүрний байгуулсан хэлэлцээр”, “Тегеран-Ялта-Потсдам”, Улаанбаатар 1973, 216-217-р тал

дэлхий дахины хүчний харьцаа социализмд ашигтайгаар өөрчлөгдөж, БНМАУ бүрэн эрхт социалист улс болж улам бүр хөгжиж бэхэжсэн зэргээс шалтгаалан хөрөнгөтөн орнуудын БНМАУ-тай харилцах харилцаагаа өөр болгосныг харуулж байлаа. Тийм ч учраас 50-иад оны сүүлчээс эхлэн өрнөдийн орнуудын олон нийтийн янз бүрийн зүтгэлтэн, байгууллага БНМАУ-ын талаар баримталдаг бодитой бус бодлогоо өөрчилж, тус улстай харилцаагаа хэвийн болгохыг засгийнхаа газруудаас улам бүр шаргуу шаарддаг болж ирсэн юм. Тэгээд ч өрнөдийн гүрнүүд БНМАУ-ыг НҮБ болон олон улсын бусад байгууллагын гишүүнээр элсүүлэхийг арга буюу зөвшөөрсөн бөгөөд дараа нь харилцаагаа хэвийн болгож эхэлсэн юм. Эдүгээ өрнөдийн гол гол орон БНМАУ-тай хэвийн харилцаа тогтоон, худалдаа, соёлын салбарт хамтран ажиллаж байна.

БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөх талаар АНУ хамгийн бурангуй бодлого баримталж байгааг баримт харуулж байна. Олон улсын хууль зүйн үүднээс үзсэн ч тэрээр уг асуудлын хувьд бодит биш байр суурь баримталж байна.

Дэлхийн социалист хамтын нөхөрлөлийн салшгүй хэсэг БНМАУ-ын гадаад харилцаа амжилттай өргөжиж, олон улсын байдал нь хэзээ хэзээнээс илүү бат бэх болов. Эдүгээ БНМАУ таван тивийн зуу шахам улстай дипломат харилцаа тогтоож, худалдаа-эдийн засаг, соёлын хамтын ажиллагаа хөгжүүлж байна. Манай улс олон улсын 60 гаруй байгууллага, олон этгээдийн өдий төдий гэрээ хэлэлцээр, конвенцид эрх тэгш үндсэн дээр оролцож байна. Өнөөгийн олон улсын харилцааны гол гол зангилаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд манай улс өөрийн зүгээс бүх талын идэвхтэй дэмжлэг туслалцаа үзүүлж байна. Энэ бүхэн нь БНМАУ-ын олон улсын байр суурийг хэлбэрэлтгүй бэхжүүлж, олон улсын үйл хэрэгт гүйцэтгэх үүргийг нь дээшлүүлж байна. Түүний хамт бүрэн эрхт БНМАУ-ын энх тайванч гадаад бодлого нь дэлхийн халуун цөмийн хөнөөлт дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, эх дэлхийд болон сансрын уудамд өнө удаан бат бэх найдвартай энх тайван байдлын төлөө тэмцэж байгаа бүх улс түмний халуун хайр талархлыг улам бүр олж байна.

СУВЕРЕННОСТЬ МНР, ЕЁ ПРИЗНАНИЕ

Резюме

Статья освещает историю борьбы Монгольской Народной Республики за обеспечение её международного признания, её прав на участие в международном общении. Автор показывает прочное международно-приваговое положение МНР в современном мире разоблачает несостоятельность и противоправный характер политики “непризнания”, кшоторую длительное время проводили западные державы и гоминьдановский Китай в отношении народной Монголии. Особо подчеркивается значение установления МНР братских отношений с СССР, другими социалистическими странами, а также дружественных связей с независимыми государствами Азии Африки. Составная часть мирового социалистического содружества-МНР ныне признана практи-

чески всеми государствами мира, со многими из них поддерживает дипломатические отношения, торгово-экономические, культурные и иные связи. Активная миролюбивая внешняя политика МНР обеспечивает неуклонное укрепление её международных позиций, завоевывает симпатию и уважение у всех народов, борющихся за предотвращение угрозы мировой термодерной катастрофы, за прочный мир на земле и в космосе.